

СЭНДЛИ ББСБ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Хурлын төрөл: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
Хурлын огноо: 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр
Хуралдсан газар: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Арт хаус центр, 6-н давхарын танхимд болон цахимаар
Хурал эхэлсэн цаг: 14:00

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг танилцуулна. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан;
2. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлүүлнэ. Үүнд:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах;
3. ТУЗ-ийн гишүүдийн улируулан сонгох тухай.

Хөтлөгч: Сайн байцгаана уу? Сэндли ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлыг эхлүүлнэ үү хэмээн өнөөдрийн хурлын даргаар ажиллаж байгаа Сэндли хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Наранбат таныг урьж байна.

Б.Наранбат: Сайн байцгаана уу? “Сэндли ББСБ” Нээлттэй хувьцаат компанийн нийт хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэнд хүргэе. Сэндли ББСБ нь нээлттэй хувьцаат компани болон хэлбэрээ өөрчилснөөс хойш бүртгэлийн өдрийн байдлаар 8213 хувьцаа эзэмшигчтэй болсон байна. Компанийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг холбогдох хууль, журмыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж, 06 тоот тогтоолоор шийдвэрлэсэн. Хувьцаа эзэмшигчдийн хурал бол компанийн эрх барих хамгийн дээд байгууллага байдаг. Энэ удаагийн хурлыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж байна. Ингээд Монгол орны өнцөг булан бүрээс цахимаар оролцож байгаа болон энд хүрэлцэн ирсэн та бүхэнд талархлаа илэрхийлэн, Сэндли ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурал нээснийг мэдэгдье. Ингээд та бүхэнд хурлын дэгийг танилцуулъя.

Хурлын дарга Б.Наранбат хурлыг эхлүүлж, хурлын дэгийг танилцуулав.

Хөтлөгч: Өнөөдрийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулсан хурлын дарга Б.Наранбат танд баярлалаа. Ингээд Хувьцаа эзэмшигчдийн ирцийн мэдээлэл гарсан байна. Тооллогын комиссын дарга А.Итгэлт танилцуулна.

А.Итгэлт: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд Сэндли ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн мэдээллийг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

**“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2025 оны 03 дүгээр сарын 31-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

***Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
хүчин төгөлдөр болсныг батлах тухай***

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, 2025 оны 03 дүгээр сарын 31-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн 2025 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байсныг дурдсугай.
2. Бүртгэлийн өдрөөр “Сэндли ББСБ” ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 223,570,000 ширхэг байснаас 2025 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д 195,299,372 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснээр нийт саналын эрхтэй хувьцааны 87,35 % болж, хурлын ирц бүрдсэнийг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
3. Хурлын ирц 87,35 % болж, хурлын ирц бүрдсэн тул “Сэндли ББСБ” ХК-ийн 2025 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал” хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

А.ИТГЭЛТ

Хөтлөгч: Хурлын ирцийг танилцуулсан Тооллогын комиссын дарга А.Итгэлт танд баярлалаа. Холбогдох хуулийн дагуу хурлын ирц хүчин төгөлдөр болсон байх тул бид хурлаа хөтөлбөрийн дагуу хурлаа үргэлжлүүлэн хурлын үндсэн хэсэгт шилжье. Сэндли ББСБ ХК-ийн 2025 оны ээлжит хурлаар танилцуулах асуудал болох Сэндли ББСБ ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлан, Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг танилцуулна уу хэмээн Хурлын дарга Б.Наранбат таныг дахин урьж байна.

Б.Наранбат: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Сэндли ББСБ” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулна.
/компанийн 2024 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулав/

Та бүхэн компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай танилцлаа. Бид анх IPO хийхдээ ногдол ашгийн бодлогоо цэвэр ашгийн 20%-ийг тараахаар тусгасан. Энэхүү бодлогынхоо хүрээнд 2022 онд цэвэр ашгийн 20,064%-ийг буюу 614,817,500 төгрөг, 2023 онд цэвэр ашгийн 20.6755% буюу 1,251,991,232.27 төгрөгийг тус тус тарааж байсан бол 2024 онд цэвэр ашгийн 20.01% буюу 1,701,367,700 төгрөгийг тараахаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар шийдвэрлэсэн. */Ногдол ашигтай холбоотой ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулав/*

Хөтлөгч. Та бүхэн танилцуулсан асуудлуудтай холбоотойгоор асуулт, хариултын цагийг эхлүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуув.

Хувьцаа эзэмшигч: Сайн байна уу? Надад нэг тодруулах зүйл байна. Мөнгөн гуйвуулга дээр 2023 онд Еврогийн гуйвуулга 2,3 сая орчим евро байж байснаа 2024 онд 1,1 сая евро болоод буурчихсан байна. Аль чиглэлдээ байна вэ? Миний ойлгосноор европоос

Монголруу чиглэлд байх шиг байна. Монголоосоо европ уруу чиглэсэн чиглэл нь 2024 оны сүүлээр 2025 оны эхээр орчихно гэж байсан, орсон байгаа юу, ороогүй байгаа юу? Энэ бууралтын шалтгаан нь юу юм бол? Энийг нэг тайлбарлаад өгөөч.

Б.Наранбат: Заа баярлалаа. Бид нар Монголоос Америк руу, Монголоос европ руу чиглэлийн, Монголоос Австрали руу чиглэлийн мөнгөн гуйвуулга дээрээ хязгаарлалттай явдаг. Нэг ёсондоо тэрийг хийх нь бидэнд ашигтай зах зээл биш гэсэн үг. Яагаад вэ гэвэл Монгол улсад байгаа Монгол улсын иргэн та бид бүгдээрээ бараг 100% шахуу банкны үйлчилгээнд хамрагдчихсан хүмүүс байдаг. Хоёр гурван банкин дээр давхар данстай байж байдаг буюу Монголоос гадагшаа мөнгө гуйвуулах нь хэцүү биш зүйл. Харин Америкаас, Европоос Монгол руу мөнгө шилжүүлэх нь хэцүү. Гадаадад байгаа Монгол хүмүүс гадаад улсын банк санхүүгийн байгууллагаар хамрагдах, үйлчилгээ авах төвөгтэй байдаг. Иймд төвөгтэй зах зээлд ажиллаж байж бид илүү их мөнгө олох боломжтой болно гэсэн үг. Дахиад нэг чухал зүйл нь бид тарт валют оруулж ирэх нь ашигтай. Тэндээс евро шилжүүлнэ, доллар шилжүүлнэ. Тэрийг нь бид нар авчраад ханш өсөлттэй байвал жаахан хадгалж байгаад 7-14 хонуулж, өсгөж байгаад зардаг. Гадагшаа гуйвуулга хийнэ гэхээр бид нар төгрөг гуйвуулж чадахгүй, жишээлбэл та 500, 1000 ам.доллар хүүхэд рүүгээ шилжүүлбэл гэвэл бид нар банкнаас доллар евро худалдаж авах болно. Тэгэхээрээ илүү өндөр үнээр авах уу, банкнууд зарах сонирхолгүй гээд асуудал үүсдэг. Бид нар Америк руу мөнгөн гуйвуулга эхлүүлчихсэн байж байхад банкнууд шилжүүлгээ багасгаад, банкнууд нь та нар Сэндлигээр шилжүүл гээд, бид нар зөрүүлээд банкнуудаас доллар гуйх асуудалд ордог. Одоо бизнес эрхэлдэг хүмүүс мэдэж байгаа шүү дээ найман шаргаас нэг юань, вон, доллар авдаг, банкнууд заримдаа зардаггүй шиг. Тэрэнтэй холбоотой юм шүү. Тэгэхээр бид аль талд нь илүү төвөгтэй байна, аль тал дээр нь илүү мөнгө олох бололцоотой байна байна вэ гэхээр монголоос гадаад руу валют шилжүүлэх биш гаднаас валют оруулж ирэх гэдэг дээр л манай Сэндли-ийн анхны үүсгэн байгуулагдсан бизнес концепт нь энэ юм. Тийм учраас бид нар Америк руу, европ руу доллар шилжүүлэх дээр хязгаарлалт хийгээд, тэрхүү үйлчилгээгээ зогсоох маягтай байна. Эргүүлээд манай харилцагч нар гадаад руу мөнгө шилжүүлэх үед бид та бүгд банкаар шилжүүлээ гэдэг. Энэ нөгөө талдаа бидний эрх нь юу вэ гэхээр Монголын арилжааны банкнуудын хийх ёстой ажил, үүргээ гүйцэтгэ, бид нар банк нарын өмнөөс ажил хийхгүй. Харин бид банкнуудын чадахгүй байгаа зүйл буюу гадаадаас валют шилжүүлэх ажлыг хийнэ. Манай мөнгөн гуйвуулга ажилдаг зах зээл бол дунджаар 200-300 ам.долларын тогтмол шилжүүлэг хийлгэдэг хүмүүс дээр ажилладаг. Банкнаас юугаараа ялгаатай вэ гэхээр 300 ам.долларыг америкийн банкнаас Монголын арилжааны банк руу шилжүүлбэл гэхээр нэг гүйлгээ болгон дээр 30-40 ам.доллар авах гээд байдаг. Тэгэхээр 300 ам.долларт чинь 10-13%-ийн хүү, шимтгэл төлөх гээд байдаг. Гэтэл манайх 300 ам.долларт ердөө 5 ам.долларын шимтгэлтэй. Энэ манай өөрийн давуу тал. Бид цуглуулж байгаад 100-200 мянган ам.доллар болонгуут нь долоо хоногтоо нэг удаа ч юмуу гүйлгээ хийгээд байдаг. Тэгэхээр Сэндли-ийн онцлог нь тэр юмаа гэж хариулая.

Хувьцаа эзэмшигч: Сайн байна уу? Ер нь ойрын үед Монголоос Япон, Солонгосруу мөнгөн гуйвуулга хийж болох уу?

Наранбат: Бид энэ оны 9-н сард үйлчилгээгээ нээнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Бид нар Солонгосын СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авахын тулд нэг тэрбум вон буюу 1,6 тэрбум төгрөгний дүрмийн сан байршуулна. Монгол улсын ББСБ-уудын дүрмийн сан 2,5 тэрбум гэдэгтэй адилхан зүйл. Наана нь маш их программ хангамж, ажилтнуудаа бэлдэх ажлуудыг 3 жил амжилттай хийж байна.

Хувьцаа эзэмшигч: Сайн байна уу? Хувьцаа эзэмшигч Даваа-Очир гэж хүн байна. Хөдөө орон нутагт 50н салбартай, хотод 7-н салбартай гэж байна. Хөдөө орон нутгаар ийм олон салбартай байхын ашиг юу вэ?, салбарууд нь ашигтай ажиллаж чаддаг уу? бүгд ашигтай

юу, эсхүл зарим нь ашигтай байна уу? Шинэ салбар нээж байгаа шалтгаан нь юу вэ? Салбаруудын үзүүлэлтүүдийг гаргаж, дүгнэдэг үү? Ажилчидаа яаж урамшуулдаг вэ? Миний бодлоор орон нутгийн салбар хэтэрхий олон юм уу гэж хараад байна. Салбаруудаа шалгаруулдаг тийм систем байгаа юу.

Наранбат: Энэ асуултанд Гүйцэтгэх захирал Б.Одгэрэлтэй хувааж хариулая. */Гүйцэтгэх захирлыг танилцуулая/*

Бид анх үүсгэн байгуулагдсан зорилго нь санхүүгийн үйлчилгээг авч чадахгүй байгаа алслагдмал газарт амьдардаг хүмүүст тэгш хүртээмжтэй үйлчилгээг хүргэх зорилгоор байгуулагдсан. Нэг ёсондоо биднийг 2017, 2018 онд орон нутагт үйл ажиллагаа явуулж эхлэхэд тэнд хамгийн том санхүүгийн байгууллага бол Төрийн банк, Хаан банк хоёр тэгээд баахан ломбардууд. Ломбардууд нь сард 10 хувийн хүүтэй. 7 хоногийн 7, 14 хоногийн бүр 14 хувийн хүүтэй өндөр ажилладаг байсан. Тэгэхээр банкнаас зээл авчхаад банк бусаас зээл авч чадахгүй хүмүүс хохирдог байсан. Бид анх очихдоо иргэдээс сарын 2,5, жилийн 30 хувийн хүүтэй эх үүсвэр татаж, сарын 5 хувийн хүүтэй, жилийн 60 хувийн хүүтэй зээл олгож, ашигласан хоногоор нь хүү тооцдог, та 7 хоног ашигласан бол 7 хоногийнхоо л хүүг төл, сарын 5 хувь бол 7 хоног 1,25 хувийн хүү төл гэдэг ийм зах зээл дэх зээлийн үйлчилгээг анх нээсэн. Манай анхдагч бааз суурь бол орон нутаг. За үүний дараа бид орон нутаг дээр санхүүгийн зээлийн бизнесийг маш амжилттай явуулсан учраас энэ финтек гэдэг бол ирээдүй юм байна, энэ зүйлтэй бид хамт байх ёстой юм байна гээд олсон ашиг орлогоосоо бид финтек руу хөрөнгө оруулалт хийж байж, финтек нь өөрөө мөнгөн гуйвуулга болж, бид ийм гэрэл гэгээтэй юм ярих, олон улсын гарцыг нээх боломж бүрдсэн. Ингэснээр та бүгдийг урьж оролцуулан, өнөөдрийн энэ сэндли үүсч, өнөөдөр бид 3 дахь жилдээ Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж байна. Түүх нь ийм учиртай. Та тэгэхээр таны асуулт гарч ирнэ. Бидэнд салбар хэрэггүй, хүн хэрэггүй, финтек гэхихээд юун ийм олон салбартай юм бэ, ашигтай юм уу гэдэг зүйл яригддаг. За салбарыг ажиллуулахад давуу болон сул талтай. Ер нь бол хэцүү. Хүн болгон олон салбар ажиллуулж чаддаггүй учир хэцүү байдаг. Миний хувьд бол олон салбартай төрийн банкны санхүү хариуцсан дэд захирал, орлогч хийж байсан туршлагатай учраас, мөн Одгэрэлтэйгээ, мөн хамт ажилласан найзууд маань нийлээд олон салбарын менежмент хийсэн. Олон салбарын менежментийн хамгийн чухал асуудал юу вэ гэхээр trans for firizing буюу үнийг шилжүүлэх гэсэн үг. Өөрөөр хэлбэл эх үүсвэр шилжүүлэх буюу зарим газар эх үүсвэр татсан бол зарим салбарт дутагдалтай байж болно бөгөөд дутагдалтай байгаа салбар руу эх үүсвэрээ шилүүлдэг тийм тогтолцоо. Салбар болгон өдөр тутам өндөрлөгөө гэж хийж байгаа. Өндөрлөгөө хийснээр тухайн салбарын ашигтай ажилласан үгүй нь гараад ирдэг. Нийт салбар 24/7 онлайн бөгөөд тус бүр 2-3 ажилтантай, 20-30 мкв байранд байрладаг. Ингэхдээ олон төрлийн үйлчилгээг үзүүлдэг. Ингээд нэг ажилтан олон төрлийн санхүүгийн үйлчилгээг иргэдэд хүргэснээрээ олон төрлийн KPI авах боломжтой болно. Нөгөө талдаа бид иргэдэд санхүүгийн үйлчилгээг үзүүлэхдээ нэг салбараар дамжуулж олон төрлийн бүтээгдэхүүн хүргэх боломжтой болж байгаа юм. Манай хувьд салбар бүртээ байнгын эргэх холбоотой байх, хяналт шалгалттай байх зарчмыг баримтлаад явж байгаа. Цаашдаа хэт нэмэхгүй байх бодлогыг баримтлаж байна.

Б.Одгэрэл: Манай салбарууд бүгд ашигтай ажилладаг. Жил бүр дүгнэдэг. Жишээлбэл, хамгийн өндөр өгөөжтэй ажиллаж байгаа салбар бол 5 тэрбумын эх үүсвэр татчихсан, 5 тэрбумын зээл олгочихсон байх жишээтэй байна. Сумын хувьд янз бүрийн ялгаатай сумууд байгаа. Бид зах зээлээ харж байж шинэ салбаруудаа нээж байгаа. Зарим сум нь зээл их олгодог байхад, зарим сум нь эх үүсвэр татдаг байх жишээтэй. Энэ жилийн хамгийн өндөр ашигтай салбарыг жилийн эцэс, улирал болгон дүгнэж явдаг. Жилийн эцэстээ салбарын захирлууддаа урамшууллын системтэй ажилладаг. Хамгийн өндөр ашигтай ажиллаж байгаа

салбарыг 300-аас дээш ашигтай ажиллаж байгаа салбарыг нэрлэж байгаа бөгөөд нийт 3-н салбар байгаа. Үүнд, Увс, Дорноговь, Хэнтий гэх мэтчилэн аймгууд байна.

Хувьцаа эзэмшигч: Надад нэг санал байна. Цаашид үйл ажиллагааны тайландаа салбаруудын харьцуулсан мэдээллийг оруулдаг баймаар байна.

Б.Одгэрэл: Заа, ойлголоо.

Хувьцаа эзэмшигч: Анх хувьцаагаа гаргахдаа олон нийтэд 29,97 хувь байсан. Одоо хувьцаагаа буцааж худалдаж аваад олон нийт 8 хувь болсон байна. Олон нийтийн хувь ингэж бага болтол нь өөрөө хувьцаагаа буцаан худалдан авсан нь ямар учиртай юм болоо? Хоёрдугаарт, ажилчдад хувьцаа эзэмшүүлэх гадны загварыг дуурайж байхаар харьцангуй жижиг компани учраас өөр аргаар ажилтнууыг урамшуулж болохгүй юу? Жишээлбэл, 13 дахь сарын цалин олгодог ч юм уу.

Б.Наранбат: Бид анх IPO хийхдээ компанийнхаа хэсэг хувьцааг тусгаарлаад Сэндли эмплөйе ХХК гэдэг компанид эзэмшүүлээд тэр компанийнхаа хувьцааг ажилчиддаа эзэмшүүлдэг. Тэгэхээр хувьцааны хөдөлгөөнд нөлөөлөхгүй. Ногдол ашиг нь тэрхүү компаниараа дамжуулаад ажилчиддаа очдог юм. Хувьцааны хувьд 8 хувийг нэмэгдүүлээрэй гэдэг дээр санал нийлж байна. Бидний хувьцааны эрэлт нэмэгдэх үед үнийн хэт хөөрөгдөлийг багасгах журмаар хувьцаагаа олон нийтэд зарах болно. Асуулт асуусан та бүхэнд баярлалаа.

Хөтлөгч: Асуулт асуусан хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа. Хэрэв та тус асуултын цагт багтаан асуулт асууж амжаагүй эсхүл дахин нэмэлт тодруулах зүйлс байвал завсарлагааны үеэр эсхүл хурлын дараа хурлын даргатай биечлэн уулзаж асуух боломжтой. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар нийт 2 асуудлыг та бүхний санал хураалтаар шийдвэрлэнэ. Санал хураалт явагдах асуудлыг танилцуулахаас өмнө та бүхэнд саналаа хэрхэн өгөх талаар зааврыг танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд Санал өгөх заавар бичлэгийг танилцуулав.

Б.Наранбат: Та бүхэн саналаа хэрхэн өгөх талаар ойлголттой болсон гэж бодож байна. Ингээд шийдвэрлэх 2 асуудлыг танилцуулъя. Танилцуулж байх хугацаанд та бүхэн саналаа өгөх бүрэн боломжтой. Би та бүхэнд ямар томъёоллын дагуу санал хураах вэ гэдгийг танилцуулъя.

Нэгдүгээр асуудлын хувьд, анх Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо бүрэн эрхийн хугацааг 3 жилээр олгож байсан. Энэ жил гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусч байгаа учир улируулан сонгохоор нэр дэвшүүлсэн байна. */ТУЗ-ийн гишүүдийг танилцуулав/*

Хоёрдугаар асуудлын хувьд, та бүхэнд танилцуулсан компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөл хуралдан дүгнэлт гаргасан бөгөөд энэхүү дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах хуулийн шаардлага байдаг.

Гуравдугаар асуудлын хувьд, ТУЗ-ийн 2025 оны жилийн төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батална. Үүнд ТУЗ-ийн хурлын зардал, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалингийн зардал багтаж байгаа болно. Үүнд бид зөвхөн үндсэн цалинг 1,000,000 төгрөг байсныг 1,500,000 сая төгрөг болгон нэмэгдүүлж, бусад зардлыг хэвээр үлдээж байгаа. Учир нь ижил төстэй бусад ХК-ийн ТУЗ-ийн цалинтай энэ зэрэгцүүлэхийг хичээж байгаа хэдий ч эхний ээлжинд өөрсдийн боломж бололцооны хүрээнд ийнхүү нэмэгдүүлэх саналыг гаргаж байна.

/гарах шийдвэрийн төслийг танилцуулав./

Та бүхэнд санал хураалт явагдах 3 асуудлыг танилцууллаа. Та бүхэн саналаа идэвхитэй өгөхийг хүсч байна. Санал хураалтын дүн гарах хүртэл та бүхэн буффетээр үйлчлүүлэн ард байгаа цай, кофе уух боломжтой. Санал өгөх талаар туслалцаа хэрэгтэй тохиолдолд манай компанийн ажилчид та бүхэнд туслах болно.

ЗАВСАРЛАГА /20 минут үргэлжилж, энэ хугацаанд санал хураалтын үйл ажиллагаа явагдав/

Хөтлөгч: Санал хураалтын шугам хаагдсан байна. Үүгээр санал хураалт явагдаж дууссан тул санал хураалтын дүнг уншиж танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга А.Итгэлтийг урьж байна.

А.Итгэлт: Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүн гарлаа. Та бүхэн танилцуулья.

“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

*Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар
хэлэлцсэн асуудал тус бүрийн саналын дүнг нэгтгэн батлах тухай*

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт, 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч тус бүр дараах байдлаар кумулятив санал авсан байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай.

№	ТУЗ-ийн гишүүдийн нэрс	Саналын тоо	Саналын хувь
Ердийн гишүүд			
1	Баттулга Наранбат	199,078,026	11,32%
2	Мөнхтөр Цолмон	195,119,564	11,10%
3	Найдан Билгүүн	194,732,309	11,07%
4	Лхагважав Нарантуяа	194,755,649	11,08%
5	Батбаяр Эрдэнэ	194,900,370	11,08%
6	Нармандах Цэвэгмид	194,524,438	11,06%
Хараат бус гишүүд			
1	Цэндсүрэн Саруултуяа	194,568,522	11,06%
2	Чойжилсүрэн Заяа	194,583,643	11,07%
3	Батмөнх Цэлмэг	194,974,888	11,09%

2. “Сэндли ББСБ” ХК-ийн “2023 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд гаргасан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай” асуудлыг хуралд оролцсон саналын эрхтэй 195,299,372 ширхэг хувьцаанаас 195,248,601 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигч буюу 99.974% зөвшөөрсөн санал, 50,771 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 0.026% нь түдгэлзсэн санал ба татгалзсан санал байхгүй байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай
3. “Сэндли ББСБ” ХК-ийн “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг батлах тухай” асуудлыг хуралд оролцсон саналын эрхтэй 195,299,372 ширхэг хувьцаанаас 195,248,601 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигч буюу 99.974% зөвшөөрсөн санал, 50,771 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 0,026% нь түдгэлзсэн санал ба татгалзсан санал байхгүй байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

А.ИТГЭЛТ

Ийнхүү санал хураалтын дүн гарсантай холбоотойгоор энэхүү хурлаас гарах шийдвэрийн төслийг уншиж танилцуулъя.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2025.03.31

№ 01

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгосугай:
 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
 1. Баттулга овогтой Наранбат;
 2. Мөнхтөр овогтой Цолмон;
 3. Найдан овогтой Билгүүн;
 4. Лхагважав овогтой Нарантуяа;
 5. Батбаяр овогтой Эрдэнэ;
 6. Нармандах овогтой Цэвэгмид.
 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 1. Цэндсүрэн овогтой Саруултуяа;
 2. Чойжилсүрэн овогтой Заяа;
 3. Батмөнх овогтой Цэлмэг.
2. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн

бирж-д хүргэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл) болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (БМөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.НАРАНБАТ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2025.03.31

№ 02

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

“Сэндли ББСБ” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03 тоот Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан “хангалттай” гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Б.НАРАНБАТ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2025.03.31

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг Хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.НАРАНБАТ

Хөтлөгч: Санал хураалтын дүнг танилцуулсан Тооллогын комиссын дарга А.Итгэлтэд баярлалаа. Ийнхүү Сэндли ББСБ ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал өндөрлөж байна. Хуралдаа идэвхтэй оролцсон та бүхэнд баярлалаа. Хурлын хааж үг хэлнэ үү хэмээн Хурлын дарга Б.Наранбат таныг урьж байна.

Б.Наранбат: Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвх санаачлагатай оролцож, өөрсдийн үнэт саналаа өгсөн та бүхэндээ баярлалаа. Компанийн цаашдын үйл ажиллагаанд та бүгдийн оролцоо юу юунаас илүү чухал гэдгийг энэ дашрамд хэлмээр байна. /хурал хааж үг хэлэх/

Ингээд “Сэндли ББСБ” ХК-ийн өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал өндөрлөснийг мэдэгдье.

ШИЙДВЭРЛЭСЭН АСУУДАЛ:

1. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож, батлав.

№	ТУЗ-ийн гишүүдийн нэрс	Саналын тоо	Саналын хувь
Ердийн гишүүд			
1	Баттулга Наранбат	199,076,925	11,32%
2	Мөнхтөр Цолмон	195,114,059	11,10%
3	Найдан Билгүүн	194,732,309	11,07%
4	Лхагважав Нарантуяа	194,755,649	11,08%
5	Батбаяр Эрдэнэ	194,900,370	11,08%
6	Нармандах Цэвэгмид	194,524,438	11,06%
Хараат бус гишүүд			
1	Цэндсүрэн Саруултуяа	194,567,421	11,06%
2	Чойжилсүрэн Заяа	194,582,542	11,07%
3	Батмөнх Цэлмэг	194,973,787	11,09%

2. Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
195,248,601	99.974%	0	0%	50,771	0.026%

3. Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлав.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
195,248,601	99.974%	0	0%	50,771	0.026%

Хурлын дарга Б.НАРАНБАТ /...../

Хурлын тэмдэглэл хөтөлсөн!
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Мөнхцэцэг /...../